



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/154

Хэрлэн сум

Сумдын Засаг даргын Тамгын газрыг урамшуулахад хөрөнгө зарцуулах

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжийн гуравдугаар хавсралтын дагуу 2024 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр эхний гурван байр эзэлсэн сумдын Засаг даргын Тамгын газрыг урамшуулахад зориулж 2,550,000 (хоёр сая таван зуун тавин мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.1 дүгээр байр эзэлсэн сумын Засаг даргын Тамгын газрын даргад үндсэн цалингийн 80%, 2 дугаар байр эзэлсэн сумын Засаг даргын Тамгын газрын даргад үндсэн цалингийн 60%, 3 дугаар байр эзэлсэн сумын Засаг даргын Тамгын газрын даргад үндсэн цалингийн 40%-тай тэнцэх мөнгөн урамшууллыг байгууллагынхаа төсвөөс олгохыг зөвшөөрсүгэй.

4.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (А.Жаргалсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

Аймгийн Засаг даргын 2025 оны
дүгээр сарын 31-ний өдрийн
А/С/4 дугаар захирамжийн хавсралт

Шаардагдах зардлын тооцоо

№	Зардлын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	1 дүгээр байрын шагнал	1	1.000.000	1.000.000
2	2 дүгээр байрын шагнал	1	800.000	800.000
3	3 дүгээр байрын шагнал	1	600.000	600.000
4	Батламж	3	50.000	150.000
Дүн				2.550.000